

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ 52 ДУГААР ТОГТООЛ “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

д/д	Зорилт, арга хэмжээ	Хугацаа	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
НАЙМ.БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ				
<u>Дэд бүтэц</u> Зорилт 8.1.Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.				
	8.1.5. Шинэ нийслэл болон Дорнод, Өмнөговь, Ховд, Увс, Завхан, Хөвсгөл аймгуудыг 4С зэрэглэлийн агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор бүхий олон улсын нисэх буудалтай болгоно.	2021-2030	<p>2024 он:</p> <p>Дорнод, Өмнөговь, Ховд, Увс, Завхан, Хөвсгөл аймгуудын нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төслийг концессоор ашиглуулах төслийн уралдаант шалгаруулалтыг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр олон нийтэд нээлттэй зарласан бөгөөд Концессын тухай хуулийн хугацаа хүчин төгөлдөр бус болсонтойгоор төслийн уралдаант шалгаруулалт тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон юм.</p> <p>Концессын тухай хуулийн хугацааг сунгах эсхүл Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг хэрэгжүүлж эхлэх эсэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхийг Эдийн засаг, хөгжлийн сайдад үүрэг болгосонтой холбогдуулан нисэх буудлуудын танилцуулгыг дахин шинэчлэн боловсруулж тогтмол цахимаар ЗТХЯ, ЭЗХЯ болон төрийн худалдан авах газруудад хүргүүлсэн.</p> <p>ЗТХЯ-ны 2024 оны 02/1811 дугаартай албан бичгээр орон нутгийн “Ховд”, “Мөрөн”, “Чойбалсан”, “Дэглий цагаан” нисэх буудлуудыг “4С” ангиллын болгох урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, ирүүлэхийг чиглэл болгосны дагуу дараах судалгаа, мэдээллийг бэлтгэж 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01/1345 дугаартай албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Түүнчлэн 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанхай хотын “ROC” компанийн холбогдох мэргэжилтэнтэй хамтран эдгээр нисэх буудлын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг олон улсад мөрдөгдөж буй аргачлалын дагуу шинэчлэн сайжруулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>“Ховд” нисэх буудлыг орон нутгийн Засаг захиргаанд үе шаттай шилжүүлэх асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, зохих шийдвэр гаргуулах хүсэлтийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу бэлтгэсэн тогтоолын төслийн хамтаар 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 01/2453 дугаартай албан бичгээр Зам, тээврийн сайдад хүргүүлсэн.</p> <p>Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл “Түншлэлийн төсөлд тавих шаардлага”-ын 18.2.1-т “Төслийн төсөв, санхүүгийн үнэлгээ, урьдчилсан болон нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байх” шаардлагатай тухай заасны дагуу Увс аймгийн “Дэглий цагаан”, Хөвсгөл аймгийн “Мөрөн”, Ховд</p>	70%

			<p>аймгийн Ховд нисэх буудлыг 4С ангиллын нисэх буудал болгон хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлж, 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн захиалгаар холбогдох тээвэр боловсруулах тендер шалгаруулалтыг зарласан. Тендер шалгаруулалтыг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр нээж, үнэлнэ.</p> <p>Шинэ нийслэл хотод баригдах 4Е ангиллын нисэх буудлын ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилт 1 тэрбум төгрөгийг 2024 оны улсын төсөвт суулгаж тендер зарласан боловч 3 удаа амжилтгүй болсонтой холбогдуулан 2025 оноос төсвийг нэмэгдүүлэн дахин зарлахаар ажиллаж байна.</p>	
<p>Дагуул хот Зорилт 9.5.Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.</p>				
	9.5.4.Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулж, Зүүн хойд азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төвийг байгуулна.		<p>2021 он: Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад 2021 онд бүрэн оруулж, үйл ажиллагааг 2021 оны 07 дугаар сараас эхлүүлсэн.</p>	100%